

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гүржавын Цэрэндаш	Дугаар	L086
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Баян-Адарга сум
Төрсөн газар	Баян-адарга сум	Төрсөн он	1921
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Сайхан модны хийд, Асартын дуган	Сүм хийдийн дугаар	ХЭБА 094, ХЭБА 093
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Сайхан модны хийд, Асартын дуган

-Та нутаг орондоо байсан хийдийн тухай мэдэх зүйлээ бидэнд хэлж өгөөч?

Сайхан модны хийд Балжийн дэргэд байсан. 40 гаран ламтай байсан.

Асартын хийд цагийн хуралтай сан тавьдаг 2, 1 ламтай, Балданбэрээвэнгийн жас байсан. Намарт үхэр цавтай байсан. Баян-Адарга сумын Дундахын адаг гэдэг газар байсан. Би Өндөр багшийн шавь байсан. Аав минь намайг шавь оруулсан.

Сайхан модны дуган 1920-оод оны үед байгуулагдсан. 50-иад ламтай байсан. Хамгийн том лам нь Өндөр багш гэж хүн байсан. Сондгойн ард одоогийн Сайхан модны баруун дов дээр байсан юм. Чүлтэм гэж дүү нь байсан юм. Ням гэлэн гэж дүү нь байсан юм. Да лам нь Чүлтэм гэлэн байсан. Цорж лам нь халзан Жамба гэлэн гэж байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Түмэнжаргалантын овоо бол эх дагина Дондогдуламын төрсөн газар юм. Богд 20-иод ламтай ирж жил болгон хурал хурдаг байсан. Өндөр лам тэр хурлыг удирдаж хуруулдаг байсан. Тэр Өндөр лам нь Өндөр толгойн орой дээр 2 жил дараалан дой босгон, толгой толгойгоор нь торго дурдан цуучиж модоор өндөр юм босгоод торгоороо ороож шатааж байсан юм. Тэр нь тэнгэр дэлхий лус найман аймгаа баясгаж байсан. (Хориод ламтай майхантай ирдэг байсан)

Архангай аймгаас хувилгаан нэртэй хаш тамгаа хулгайлж аваад манай Жонон вангийн хошуу буюу одоогийн Балжид Халзан толгой гэдэг газар ирж нутаглаж байгаад лам болж Сайхан модны дуганыг ард олноор бариулж байгуулж байсан юм.

Асартын хийдийг анх 1884 онд одоогийн Дундахын адагт хуучин бригадын төв байсан газарт байгуулсан бөгөөд Балданбэрээвэн хийдийн салбар хийд байсан юм. Өндөр лам 1930-аад оны үед баригдсан.